



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/410

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2022 оны XI/03 дугаар хуралдаанаар батлагдсан "Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр", аймгийн Засаг даргын 2023 оны захирамжаар баталсан "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай" А/112 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хангайн бүсийн Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Булган аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан төрийн албан хаагчдыг хамруулсан "Үр дүнд суурилсан удирдлага" сэдэвт сургалт семинарыг үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Сургалтад шаардагдах 9.571.000 (есөн сая таван зуун далан нэгэн мянга) төгрөгний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрхи зардлыг санхүүжүүлэхийг төсөл, хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6323010464

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дүгээр  
...сарын 23 ний өдрийн А/410 захирамжийн хавсралт

"Үр дүнд суурилсан удирдлага" сургалт семинарын зардал

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Үнэ	Дүн
1	Хоол	100	40,500	4,050,000
2	Цай, кофе	530	1,100	583,000
3	Бургер	200	6,500	1,300,000
4	Печень	400	2,500	1,000,000
5	Аяга	500	100	50,000
6	Ус	360	1,500	540,000
7	Ундаа	90	2,500	225,000
8	Халбага	23,000	1	23,000
9	Бусад	50	36,000	1,800,000
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>9,571,000</b>